

БАТЛАВ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Ц.ЭРДЭНЭСҮРЭН



**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗДТГАЗАР**

**ОГНОО 2017.09.05**

**ЦАХИМ АЙМАГ ХӨТӨЛБӨРИЙН ЦАХИМ ХУРЛЫН ТӨХӨӨРӨМЖ  
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОХ ЦАХИМ ҮНИЙН САНАЛ АВАХ  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер  
шалгаруулалт/  
гэрээний нэр, дугаар:

ДУАОНӨГ/201704034

## **Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар, Орон нутгийн өмчийн газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос цахим аймаг хөтөлбөрийн цахим хурлын төхөөрөмж нийлүүлэгчийг сонгох цахим тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу. Мөн цахим тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан "Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам"-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50.000 (тавин мянган) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2017 оны 09 сарын 15-ны өдрийн 11:00 цагаас өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2017.09.15-ны өдрийн 11:30 цагт нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

***Дундговь аймгийн нутгийн удирдлагын ордон  
Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар  
Харилцах утас: 70593399 99084193***

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |   |
|---|---|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.   |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.  |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, / болон бусад баримт бичиг;<br>(д) Харьяа татварын хэлтэст өргүй талаарх тодорхойлолт   |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.  |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.   |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>45</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |
| <b>7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</b>            | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.<br>7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь <b>ТШӨХ-д</b> заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.<br>7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| <b>8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл</b>      | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.   |

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> <li>1. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2016 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт</li> <li>2. Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 1 жилийн борлуулалтын орлого нь 20 сая төгрөгөөс багагүй байх</li> <li>3. Харьяа татварын хэлтэст өргүй талаарх тодорхойлол 2017 оны 07 сарын байдлаар /QR кодтой/</li> <li>4. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар нотариатаар баталгаажуулсан</li> <li>5. Сүүлийн 1 жилийн буюу 2016 оны туршлагын мэдээлэл /ижил төстэй бараа гэрээгээр гүйцэтгэсэн тухай гэрээний хуулбар, хүлээлгэн өгсөн тухай акт/</li> <li>6. Барааны нэр, загвар үзүүлэлт, фото зураг</li> </ol>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>) хаягаар өөрийн ААН-ийн тоон гарын үсгийг ашиглан нэвтрэж цахим хэлбэр (PDF)-ээр илгээнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50'000 /тавин мянган/ төгрөгийг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-ээр банкны е-меркантийн системийг ашиглан төлнө.</p> <p>Тендер хүлээн авах хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p> <p>Огноо: <b>2017-09-15</b></p> <p>Цаг: <b>11:00 цаг хүртэл</b></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Дундговь аймаг, Нутгийн удирдлагын ордон ЗДТГ 3-н давхар Орон нутгийн өмчийн газар 323 тоот өрөө</p> <p>Огноо: 2017-09-15</p> <p>Цаг: 11:30 цаг</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: бараа нийлүүлэх ажил</p>

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Барааны тодорхойлолт:** Aver нэрийн EVC950 болон EVC350 загварын үзүүлэлттэй дүйцэхүйц 2 багц цахим хурлын төхөөрөмж дагалдах хэрэгслийн хамт. /Техникийн үзүүлэлтийг хавсаргав/
2. **Стандарт:** Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна.
3. **Баглаа, боодол:** Зориулалтын
4. **Бараа хүргэх газар:** Дундговь аймгийн ЗДТГазар
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

### БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
Багц төхөөрөмж	Багц төхөөрөмж/ видео кодек, камер, спикер болон микрофоны систем, алсын зайн удирдлага хамтдаа багц үнээр бодогдоно. Өөртэйгээ 10 хэрэглэгч холбогдох боломжтой байх. Нэг техник тутмын үнэ гэж байхгүй <b>Aver EVC950 видео төхөөрөмжийн үзүүлэлттэй дүйцэхүйц байна.</b>	1	багц	Дундговь аймаг ЗДТГ	2017.10.15	2017.10.20	
Багц төхөөрөмж	Багц төхөөрөмж/ видео кодек, камер, спикер болон микрофоны систем, алсын зайн удирдлага хамтдаа багц үнээр бодогдоно. Өөртэйгээ 6 хэрэглэгч холбогдох боломжтой байх. Нэг техник тутмын үнэ гэж байхгүй <b>Aver EVC350 видео төхөөрөмжийн үзүүлэлттэй дүйцэхүйц байна.</b>	1	багц	Дундговь аймаг ЗДТГ	2017.10.15	2017.10.20	
Дэлгэц	48 инч HDMI оролттой	2	ш	Дундговь аймаг ЗДТГ	2017.10.15	2017.10.20	
Дэлгэц хананд тогтоогч		2	ш	Дундговь аймаг ЗДТГ	2017.10.15	2017.10.20	

Суурилуулалт хийхэд хийхэд шаардагдах материал /Хана болон шалны утас далдлагч, олон залгуур/		1	ш	Дундговь аймаг ЗДТГ	2017.10.15	2017.10.20	
Видео хурлын төхөөрөмж хананд тогтоогч		2	ш	Дундговь аймаг ЗДТГ	2017.10.15	2017.10.20	
Бодит хаяг		2	ш		2017.10.15	2017.10.20	

## Видео төхөөрөмжийн техникийн үзүүлэлт нь дор дурдсанаас багагүй байна

### Цахим аймаг хөтөлбөрийн “Цахим хурлын төхөөрөмжүүдийн багцын техникийн тодорхойлолт

#### Нэг. AVer EVC950 болон EVC350 видео төхөөрөмжийн техник үзүүлэлт

Front panel



Back panel



1	Холболтын үзүүлэлт	SIP, H.323, багадаа 64 Kbps ба ихдээ 4.0 Mbps интернетийн хурданд ажиллана. RJ-45 Network LAN 10/100/1000 холболтоор холбогдоно. Автоматаар зурвасын өргөнөө тохирууладаг. <b>AVER EVC950</b> нь өөр дээрээ <b>10 хэрэглэгчийг Full HD</b> зэр холбох боломжтой. <b>AVER EVC350</b> нь өөр дээрээ <b>6 хэрэглэгчийг Full HD</b> зэр холбох боломжтой.
2	Дэмжих дэлгэц	<ul style="list-style-type: none"> <li>• VGA кабелиар холбоход</li> <li>• 1080p (1920 x 1080)</li> <li>• 720p (1280 x 720)</li> <li>• D1 (720 x 480)</li> <li>• SXGA (1280 x 1024)</li> <li>• XGA (1024 x 768)</li> <li>• SVGA (800 x 600)</li> <li>• VGA (640 x 480)</li> </ul> <p>DVI кабелиар холбоход</p> <ul style="list-style-type: none"> <li>• 1080p (1920 x 1080)</li> <li>• 720p (1280 x 720)</li> <li>• D1 (720 x 480)</li> <li>• SXGA (1280 x 1024)</li> <li>• XGA (1024 x 768)</li> <li>• SVGA (800 x 600)</li> <li>• VGA (640 x 480)</li> <li>• All resolutions at 30fps</li> <li>• 720p эсвэл 1080p HD үзүүлэлттэй HDMI оролттой дурын дэлгэцийг дэмжинэ.</li> </ul>
3	VIDEO оролт	1. eCAM PTZ II камерын оролтыг дэмждэг

		<ul style="list-style-type: none"> <li>2. VGA дэмждэг</li> <li>3. DVI (HDMI)</li> </ul>
4	VIDEO гаралт	<ul style="list-style-type: none"> <li>1. HDMI дэмждэг</li> <li>2. VGA дэмждэг–хоёрдахь дэлгэц</li> </ul>
5	Аудио оролт	<ul style="list-style-type: none"> <li>1. 3,5мм–ийн Mic/Line оролт</li> <li>2. EVC микрофоны оролттой 4 ийг холбох боломжтой</li> <li>3. DVI (HDMI)</li> </ul>
6	Аудио гаралт	<ul style="list-style-type: none"> <li>1. Line Out (3.5mm) буюу чихэвчний гаралт</li> <li>2. DVI-I гаралт болон HDMI</li> </ul>
7	Бусад SUPPORT-н стандартууд	<ul style="list-style-type: none"> <li>• H.224, H.225, H.245, H.281, H.323 Annex Q, H.460</li> <li>• SRTP</li> </ul>
8	Хэрэглэгчийн интерфэйс болон онцлог	<ul style="list-style-type: none"> <li>❖ Хялбаршуулсан хэрэглэгчийн интерфэйс</li> <li>❖ Хялбар алсын зайн удирдлагаар бүх асуудлыг шийдэх</li> <li>❖ Олон хэрэглэгчийн дуудлагыг зэрэг хүлээн авах</li> <li>❖ Хэрэглэгчийн график интерфэйсийг удирдах</li> <li>❖ Олон хэлний сонголт</li> <li>❖ Do Not Disturb горим. Өөрөөр хэлбэл өөр дуудлага хүлээн авахгүй байхаар тохируулах</li> <li>❖ Дүрсийг дуугүйгээр дамжуулах</li> <li>❖ Дэлгэцэн дээрх нэр болон газрын нэрийг өөрчлөх боломжтой.</li> </ul>
9	Нэмэлт талууд давуу	<ul style="list-style-type: none"> <li>❖ Хуралын бичлэгийн хувь <ul style="list-style-type: none"> <li>• Офлайнаар хадгалдаг</li> <li>• USB флаш дискрүү шууд хурлыг хуулдаг</li> <li>• VCPlayer дэмждэг буюу (.mov/.mp4) форматаар бичлэг нь гарч ирдэг</li> <li>• Бичлэгийн богино хугацаанд хуулах боломжтой</li> </ul> </li> <li>❖ Тасралтгүй үргэлжилсэн дуудлага хүлээн авах</li> <li>❖ Хуанли, уулзалтын сан, хайлтын систем</li> <li>❖ Удирдлагын сан</li> <li>❖ Автомат хадгалалт буюу нөөцлөлт</li> <li>❖ Зочны дуудлага</li> <li>❖ Видео сүлжээний удирдлага</li> <li>❖ Сүлжээний Цагийн Protocol (NTP)</li> <li>❖ ScreenShare дэмжлэг</li> <li>❖ VCLink дэмжлэг</li> <li>❖ Firewall traversal, NAT-н аюулгүй байдал</li> <li>❖ Автоматаар программ хангамжаа шинэчлэнэ</li> </ul>
10	Хамгаалалт, нууцлал	<ul style="list-style-type: none"> <li>• AES (Advanced Encryption Standard) function (128bit)</li> <li>• HTTP, SSH үйлчилгээг идэвхгүй болгох чадвартай</li> <li>• Системийн нууц код</li> <li>• Нууц кодыг хамгаалах системтэй</li> </ul>
11	Ухаалаг сүлжээний онцлог	<p>Сүлжээний бүх нөхцөлд NAT/firewall traversal (H.460/SIP)-г нэвтэрч, байж болох дээд хэмжээгээр дүрсийг дамжуулахын тулд хандалтыг хянаж тохируулах (AMC - Adaptive motion control) болон урьдчилсан залруулалт (FEC - forward error correction) автомат горимд ажилладаг.</p>
12	Удирдлагын сан болон лавлах цэс	<ul style="list-style-type: none"> <li>• Олон улсын хайлтын хэрэгсэлтэй</li> <li>• Хуанли болон уулзалтын хуваарийг тэмдэглэнэ</li> <li>• H.323 URI дуудлага дэмжинэ</li> </ul>
13	Удирдлагын систем	<ul style="list-style-type: none"> <li>• Вэб интерфэйстэй</li> <li>• Автомат тохируулгатай</li> <li>• SNMP</li> <li>• Нөөцлөлт (Backup) болон сэргээх (restore) боломжуудтай</li> <li>• Web-д суурилсан алсын хандалттай</li> <li>• Web ээр real time мониторинг хийх боломжтй</li> </ul>



## Видео камер нь дор дурдсанаас багагүй үзүүлэлттэй байна

14	Тэжээл	<ul style="list-style-type: none"> <li>Хувьсах гүйдлийн хүчдэлийн 100-240V</li> <li>50-60Hz гадаад цахилгаан хангамж дамжуулалт 4А дэмжин ажиллана</li> </ul>
15	Орчны нөлөөний зохистой өгөгдөлүүд	<ul style="list-style-type: none"> <li>Ажиллах үеийн температур: 0°C (32°F) –ээс 40°C (104°F)</li> <li>Ажиллах үеийн чийгшил: 20% -аас 80% хүртэл, конденсатгүй</li> <li>Хадгалалтын температур: -20°C (-4°F) -аас 80°C (140°F)</li> <li>Хадгалах үеийн чийгшил: 10% -аас 90% хүртэл, конденсатгүй</li> </ul>
16	Видео төхөөрөмжийн хэмжээ	<ul style="list-style-type: none"> <li>Өргөн: 260"</li> <li>Зузаан: 158.7"</li> <li>Өндөр: 33"</li> </ul> <p>Багц төхөөржийн нийт жин 4kg</p>
17	Моделийн дугаар	EVC950 codec

### Хоёр. EVC950 болон EVC350 төхөөрөмжийн eCAM II буюу видео камерийн техник үзүүлэлт



1	Ерөнхий үзүүлэлт	Хэвтээ тэнхлэгч 88 градусын чиглэлт талбарыг харах ба 18х томруулалттай. Урьдчилан тохируулсан 10 цэгт автоматаар шилжиж хөдлөх чадвартай. Стандарт 3м HDMI кабельтай
2	Дүрсний ерөнхий техник үзүүлэлт	Хамгийн ихдээ 1920x1080 нягтралтайгаар, 16:9 аспектийн харьцаатайгаар үзүүлнэ. Секунд тутамд 50 болон түүнээс дээш тооны дүрс дамжуулах чадвартай гэсэн үг. 200 гаруй нягтралыг дэмжиж ажиллана. Жишээ болгож интернетийн хурд болон дүрс дамжуулах нягтралыг үзүүлье: (H.264 High Profile, AAC-LD): <ul style="list-style-type: none"> <li>600 Kbps интернетийн хурданд 720р30 нягтралтайгаар</li> <li>820 Kbps интернетийн хурданд 720р60 нягтралтайгаар</li> <li>1.2 Mbps интернетийн хурданд 1080р30 нягтралтайгаар</li> <li>1.7 Mbps интернетийн хурданд 1080р60 нягтралтайгаар тус тус дүрсийг дамжуулна</li> </ul>
3	Видео стандарт	H.264 , H.264 High Profile, H.264 SVC, H.263+, H.263, H.239 dual video stream, BFCP content sharing
4	Нягтрал	1920x1080 / 1280x720 буюу Full HD
5	Дүрс дамжуулах хурд	1/50 (50Гц)
6	Дүрс дамжуулах хэмжээ	16: 9
7	Гэрэл өгөх	Авто / EV тохируулга
8	Гажуудал	5% хүрэхгүй хэсэг
9	Мэдрэгч төрөл	CMOS/FOV
10	Үр дүнтэй пиксел	2.073.600
11	Хөдөлгөөн хийх чадвар	Хэвтээ тэнхлэгт эргэх хэмжээ: +/- 87.5 ° (245°) Босоо тэнхлэгт харах хэмжээ +/- 30 ° (102°)

**Спикер болон микрофоны систем нь дор дурдсанаас багагүй үзүүлэлттэй байна**

12	Оптик Zoom	10x
13	Эрчим хүчний хангамж	100-240VAC 50 / 60HZ 20w ердийн, 46w хамгийн их
14	Хэмжээ	Өргөн: 137.7 мм, зузаан: 122 мм , Өндөр: 130 мм Жин: 1.4 кг
15	Байгаль орчны үзүүлэлт	Үйлдлийн Температур: 0 ° C (32 ° F) 40 ° C (104 ° F) Үйлдлийн чийгшил: 15%% 85, noncondensing Хадгалах температур: -20 ° C (-4 ° F) 60 ° C (140 ° F) Хадгалалт чийгшил: 10%% 90, noncondensing

**1. Гурав. AVer EVC950 болон EVC350 төхөөрөмжийн Дижитал MicPod буюу СПИКЕР БОЛОН МИКРОФОНЫ СИСТЕМ**



1	Ерөнхий үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> <li>• 90 Hz –ээс 22 kHz хүртэлх дуу авиаг таньж дамжуулна.</li> <li>• 4.57m хүртэлх хэлбэлзэж буй аудиог барьж чадна (15 ft)</li> <li>• Видео хурлын төхөөрөмжтэйгээ холбогдох 4м урт кабельтай</li> <li>• 4 хүртэлх тооны AVER EVC950P Digital MicPod-г дэмжих боломжтой</li> </ul>
2	Аудио үзүүлэлтүүд	<ul style="list-style-type: none"> <li>• WebRTC NetEQ нууцлалтай</li> <li>• Байгалийн яриа нь бүрэн дуплекс</li> <li>• Цуурайталтыг арилгаж, үндсэн авиаг дамжуулна</li> <li>• Автомат хяналтын тохиргоотой</li> <li>• Агаарын дуу чимээг автоматаар бууруулна</li> </ul>
3	Аудио стандарт	G.711, G.722, G.722.1 болон G.722.1C Polyscom®-аас гаргасан тусгай зөвшөөрөлийн MPEG-4-AAC-LC, MPEG-4 AAC-LD стандартууд
4	Хэмжээ	Өргөн: 131.9 мм, зузаан: 118.6 мм , Өндөр: 25 мм Жин: 1.2 кг
5	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>• Тасалгааны агаарын дуу чимээг багасгаж дамжуулна</li> <li>• Орчны давамгайлсан дуу авиаг шүүж дамжуулах чадвартай</li> <li>• Өөртөө дууг хаах болон нээх товчлууртай</li> <li>• Нано технологиор үйлдвэрлэгдсэн</li> </ul>

**Дөрөв. AVER EVC950 болон EVC350 төхөөрөмжийн remote control буюу алсын зайн удирдлага**



1	Ажиллах зарчим	Алсын хяналтын хэт ягаан туяаны (IR) мэдрэгч камерын өмнө байрладаг.
2	Алсаас удирдах зай	Алсын хяналтын дохио хүлээн авах чадвар нь 10 метр өөрөөр хэлбэл 10м зайнаас төхөөрөмж болон камерийг удирдах боломжтой

**Зургаа. Цахим хурлын тоног төхөөрөмж нийлүүлэх төсөв**

<b>Д/д</b>	<b>Нэр</b>	<b>Нэг бүрийн үнэ</b>	<b>Нийт тоо ширхэг</b>	<b>Нийт үнэ</b>
1	Багц төхөөрөмж/видео кодек, камер, спикер болон микрофоны систем, алсын зайн удирдлага хамтдаа багц үнээр бодогдоно. Өөртэйгээ <b>10 хэрэглэгч</b> холбогдох боломжтой байх. Нэг техник тутмын үнэ гэж байхгүй.	14,000,000	1 багц	14,000,000
2	Багц төхөөрөмж/видео кодек, камер, спикер болон микрофоны систем, алсын зайн удирдлага хамтдаа багц үнээр бодогдоно. Өөртэйгээ <b>6 хэрэглэгч</b> холбогдох боломжтой байх.Нэг техник тутмын үнэ гэж байхгүй.	9,100,000	1 багц	9,100,000
2	Дэлгэц 48 инч HDMA оролттой	1200,000	2	2,400,000
3	Дэлгэц хананд тогтоогч	50,000	2	100,000
4	Суурилуулалт хийхэд шаардагдах материалууд /Хана болон шалны утас далдлагч, Олон залгуур/	100,000	1	100,000
5	Видео хурлын төхөөрөмж хананд тогтоогч	50,000	2	100,000
6	Бодит хаяг	100,000	2	200,000
	<b>Нийт</b>			<b>26,000,000</b>

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |       |  |
|---|-------|--|
| <b>1. Шалгах болон турших</b>                             | 1.1.  | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b> | 2.1.  | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| <b>3. Оюуны өмчийн эрх</b>                                | 3.1.  | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| <b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>     | 4.1.  | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| <b>5. Баталгаат засварын хугацаа</b>                      | 5.1.  | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 6 сараас багагүй байна.   |
| <b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>                        | 6.1.  | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| <b>7. Төлбөр</b>  | 7.1.  | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| <b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>                         | 8.1.  | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| <b>9. Алданги оногдуулах</b>                              | 9.1.  | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| <b>10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах</b>         | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.  |
| <b>11. Маргааныг шийдвэрлэх</b>                           | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |



## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгаж, туршиж хүлээн авна.   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b> | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br><br>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;<br>2) барааны гарал үүслийн гэрчилгээ.<br><br>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна. |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>                                  | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.<br><br>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]   |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br><br>Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.  |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup></b>                  | 9.1. Алданги оногдуулах хувь: Нэг 7 хоногт 0.5<br><br>Алдангийн нийт дүн:   |

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.



Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*